

ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2026.08.05

Онцгой байдлын ерөнхий газрын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Зорилт 11.1-д "Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв (К9) байгуулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулах" арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд Монгол Улсад олон улсын жишигт нийцсэн Үндэсний эрэлч нохойн сургалтын төв (К9)-ийг байгуулж, гамшгийн үеийн эрэн хайх, аврах ажиллагаанд ажиллах эрэлч нохой, нохой хөтлөгчийг сургах, бэлтгэх, үнэлгээжүүлэх, мэргэшүүлэх, улмаар үндэсний хэмжээнд тогтвортой сургалтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсрууллаа.

Хүлээгдэж буй үр дүн:

- Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн (К9) байгуулагдана.
- Хангайн, Баруун, Хойд, Зүүн, Говийн бүсүүдэд эрэлч нохойн сургалтын нэгжүүд үе шаттайгаар байгуулна.
- Эрэлч нохой, нохой хөтлөгчийг олон улсын стандартын дагуу сургах, бэлтгэх, үнэлгээжүүлэх тогтолцоо бүрдэнэ.
- Гамшгийн үеийн эрэн хайх, аврах ажиллагааны шуурхай байдал, үр нөлөө дээшилнэ.
- Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн, нэгжийн сургалт, бэлтгэл, үнэлгээний нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.

Төслийг Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Газар хөдлөлт, хот доторх эрэн хайх, аврах ажиллагааны хэлтэс болон Эрэлч нохойн сургалтын төв хамтран боловсруулсан бөгөөд дараах баримт бичгийг хавсаргав. Үүнд:

1. Хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл;
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах тушаалын төсөл;
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
4. Барилга байгууламж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн тооцоо;
5. Төслийн танилцуулга.

Гамшгийн үед нэрвэгдэгсдийг шуурхай эрэн хайж, аврах ажиллагааны үр дүн нь мэргэжлийн боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, эрэлч нохойн бэлтгэл, чадавхаас шууд хамаардаг. Эрэлч нохой нь барилга байгууламжийн нуранги, ой, тал хээр, ус болон хүн хүрч ажиллахад хүндрэлтэй орчинд амьд хүн илрүүлэх өндөр чадвартай бөгөөд дэлхийн олон оронд эрэн хайх, аврах ажиллагаанд үр дүнтэй ашиглагдаж байна.

Иймд "Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн (К9) болон Хангайн, Баруун, Хойд, Зүүн, Говийн бүсүүдэд эрэлч нохойн сургалтын нэгж байгуулах (2026–2030 он)" хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлтэй танилцаж, саналыг ирүүлнэ үү.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДЭСНИЙ ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТ,
БЭЛТГЭЛИЙН ТӨВ (К9) БОЛОН ХАНГАЙН, БАРУУН, ХОЙД, ЗҮҮН, ГОВИЙН БҮСИЙН
ТӨВҮҮДЭД ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТЫН НЭГЖИЙГ БАЙГУУЛАХ ХӨТӨЛБӨР,
ТӨЛӨВЛӨГӨӨ
(2026-2030 ОН)**

Нэг.Нийтлэг үндэслэл

Гамшгийн үед нэрвэгдэгсдийг шуурхай эрэн хайх, амь насыг авран хамгаалах ажиллагааны үр нөлөө нь эрэн хайх, аврах хүч хэрэгслийн бэлэн байдал, чадавх, техник технологийн хангамжаас шууд хамаардаг. Энэ хүрээнд эрэлч нохой нь нуранги, ой мод, тал хээр болон хүн хүрч очиход хүндрэлтэй орчинд төөрсөн, сураггүй болсон иргэдийг богино хугацаанд илрүүлэх өндөр чадвартай, олон улсын хэмжээнд үр нөлөө нь нотлогдсон тусгай зориулалтын хүч хэрэгсэл юм.

Иймд дэлхийн олон улс эрэлч нохойг бэлтгэх, сургах тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэх, мэргэшсэн сургагч багш, дадлагажуулагчийг бэлтгэх, сургалт, дадлагын орчныг хөгжүүлэхэд онцгой анхаарч байна. Эрэлч нохойг үр дүнтэй ашиглахад цаг хугацаа, хүн хүчийг хэмнэх боломжтой боловч энэ нь зөвхөн ур чадвартай, мэргэшсэн эрэлч нохой хөтлөгчийн үйл ажиллагаагаар хэрэгждэг. Бэлтгэгдсэн эрэлч нохой хөтлөгчгүйгээр эрэлч нохойн чадамж бүрэн хэмжээнд ашиглагдах боломжгүй юм.

Байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгийн үед үүрэг гүйцэтгэх чадвартайгаар бэлтгэхийн тулд жилийн дөрвөн улиралд тасралтгүй сургалт, дадлагыг зохион байгуулах шаардлагатай. Энэ нь цаг уур, орчны эрс тэс нөхцөлд ажиллах ур чадварыг төлөвшүүлж, бодит нөхцөлд дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болдог.

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдол бүрд шуурхай хүрч ажиллахад цаг хугацааг хэмнэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв (К9) болон бүсийн төвүүдэд эрэлч нохойн сургалтын нэгжийг олон улсын холбогдох стандартад нийцүүлэн байгуулж ажиллах шаардлага үүсээд байна.

Хоёр.Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Онцгой байдлын байгууллагын Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв (К9) болон Хангайн, Баруун, Хойд, Зүүн, Говийн бүсийн төвүүдэд эрэлч нохойн сургалтын нэгжийг байгуулах (2026-2030 он) хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

1. Олон улсын стандартын зарчимд – нийцсэн эрэн хайх, аврах ажиллагаанд холбогдох удирдамж, шаардлагыг мөрдөх;
2. Шинжлэх ухаанд суурилсан сургалтын арга – эрэлч нохойн зан үйл, үнэрийн физиологи, сургалтын шатлалын аргачлалыг олон улсын түвшинд нийцүүлэх;
3. Материаллаг баазыг бэхжүүлэх зарчим – албаны барилга байгууламж, сургалтын талбай, эрэлч нохой, нохойн дулаан байр, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, нохойн тоног хэрэглэлийг үе шаттайгаар бүрдүүлэх;
4. Хүний нөөцийг тогтвортой хөгжүүлэх зарчим – эрэлч нохой хөтлөгч, багш сургагч, мэргэжилтнүүдийг шат дараатай бэлтгэж мэргэшүүлэх.

Гурав.Хөтөлбөр, төлөвлөгөөний зорилго

Онцгой байдлын байгууллагын Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв (К9) болон Хангайн, Баруун, Хойд, Зүүн, Говийн бүсийн төвүүдэд эрэлч нохойн сургалтын

нэгжүүдийг байгуулан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, албаны онцлог, олон улсын жишигт нийцсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулан эрэн хайх, аврах чадавхыг сайжруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулахад хөтөлбөр, төлөвлөгөөний зорилго оршино.

Дөрөв.Хөтөлбөр, төлөвлөгөөний зорилт

Хөтөлбөр, төлөвлөгөөний зорилгод хүрэхийн тулд дараах зорилт (хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хамт) -ыг дэвшүүлж байна. Үүнд:

- 1.Эрх зүйн орчныг боловсронгуй болгох:
 - 1.1.Дотоод, гадаадын холбогдох хууль, тогтоомжийн судалгааг хийх;
 - 1.2.Олон улсын стандарт болон дотоодын хууль, тогтоомжтой уялдуулан, холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсруулж, батлуулах;
 - 1.3. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв болон бүсүүдэд эрэлч нохойн сургалтын нэгжийн бүтэц, орон тоог батлуулах;
2. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийг олон улсын жишигт нийцүүлэн байгуулах:
 - 2.1. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн барилга байгууламж, сургалтын талбайн зураг төсөл (Албаны барилга, нэгдсэн нохойн байр, мал эмнэлэг, дотор сургалтын байр, сургалтын талбай гэх мэт)-ийг боловсруулах;
 - 2.2.Барилга байгууламж, сургалтын талбайн төсвийг боловсруулах;
 - 2.3.Барилга байгууламжийн гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд мэргэжлийн чиглэлээр хяналт тавьж, хамтарч ажиллах;
- 3.Эрэлч нохойг бэлтгэх сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах:
 - 3.1.Тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж, шаардагдах төсвийг боловсруулах;
 - 3.2.Тоног төхөөрөмж худалдан авах талаар тендер зарлах;
 - 3.3.Тоног төхөөрөмжийг суурилуулах;
- 4.Эрэлч нохой хөтлөгчдийг бэлтгэх, сургах:
 - 4.1.Эрэлч нохой хөтлөгч бэлтгэх сургалтын хөтөлбөр (төрөл мэргэжил нэг бүрээр)-ийг боловсруулах;
 - 4.2.Эрэлч нохой хөтлөгч бэлтгэх сургалт (төрөл мэргэжил нэг бүрээр)-ыг зохион байгуулах;
 - 4.3.Үнэлгээ, шалгалтыг олон улсын стандартын дагуу үзүүлэлтээр боловсруулах;
- 5.Эрэлч нохойг бэлтгэх:
 - 5.1.Эрэлч нохойн сонгон шалгаруулалт явуулах нохойн үржлийн газруудаар судалгаа хийж худалдан авах;
 - 5.2.Худалдан авсан нохойг сургалт, дадлагад хамруулах;
 - 5.3.Холбогдох шаардлагад тэнцсэн нохдыг IRO operational record sheet, FEMA canine report form-ын бичиг баримтыг үндэслэн шалгалт авч гэрчилгээжүүлэх;
 - 5.4. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв, бүсийн эрэлч нохойн нэгжүүдэд албаны нохойгоор хангах;

Тав. Хөтөлбөр, төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт

5.1.Онцгой байдлын ерөнхий газрын бүтэц (Бодлого төлөвлөлтийн газар, Захиргаа, эрх зүй, хүний нөөцийн газар, Гамшгаас хамгаалах сургалтын газар, Ажиллагааны удирдлагын газар, Санхүү, ар талын газар)-ийн нэгж, Эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв (K9) болон бүсийн төв дэх эрэлч нохойн сургалтын нэгж, орон нутаг дахь эрэлч нохой, нохой хөтлөгч алба хаагч нарт хариуцсан чиглэлийн дагуу хяналт тавьж ажиллана.

5.2.Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газар, Гамшгаас хамгаалах сургалтын газрын дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх

Эрэлч нохойн сургалтын төвөөс бүс дэх эрэлч нохойн сургалтын нэгж болон орон нутаг дахь эрэлч нохой, нохой хөтлөгч нарт мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Зургаа.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа

6.1.Нэгдүгээр үе. 2026-2027 онд:

6.1.1.Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв (К9)-ийг байгуулах;

6.1.2. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн барилга байгууламж, сургалтын талбайн зураг төсөл, төсвийг боловсруулах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

6.1.3.“Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага”-үндэсний стандартад нэмэлтээр Онцгой байдлын байгууллагын Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв болон бүс, төв, орон нутаг дахь нэгжүүдийн бүтэц, орон тооны жишгийг боловсруулж, батлуулах.

6.2.Хоёрдугаар үе. 2027-2028 онд:

6.2.1. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн барилга байгууламж, сургалтын талбайн төсвийг батлуулах;

6.2.2. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн барилга байгууламжийн тендерийг зарлаж, угсралтын ажил эхлүүлэх;

6.2.3.Тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж, шаардагдах төсвийг боловсруулж, батлуулах.

6.3.Гуравдугаар үе. 2028-2029 онд:

6.3.1. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн барилга, байгууламжийг хүлээн авах;

6.3.2.Эрэлч нохойн сургалтын орчин бүрдэж, стандартыг мөрдөж эхлэх;

6.3.3.Төв болон бүсийн нэгжүүдийн Онцгой байдлын байгууллагуудын 50-60 хувийг стандартад нийцсэн эрэлч нохойгоор хангасан байх;

6.3.4.Тоног төхөөрөмжийн жагсаалтын дагуу худалдан авах талаар тендер зарлах.

6.4.Дөрөвдүгээр үе. 2029-2030 онд:

6.4.1. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийг холбогдох стандартын дагуу тохижуулсан байна.

6.4.2.Онцгой байдлын байгууллагад эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлснээр гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед эрэлч нохойг эрэн хайх, аврах үйл ажиллагаанд дараах байдлаар ашиглана. Үүнд: Нурангиас эрэн хайх, аврах, уснаас эрэн хайх аврах, төөрсөн, сураггүй болсон иргэдийг эрэн хайх, аврах ажиллагаанд татан оролцуулснаар үр дүн 30-50 хувиар нэмэгдэж дээшилсэн байна.

6.4.3.Эрэлч нохойн шинэчилсэн сургалтын хөтөлбөр бүрэн хэрэгжиж, сургалтын чанар 80-90 хувиар өссөн байна.

6.4.4. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв, бүсүүдийн эрэлч нохойн сургалтын нэгжүүдэд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг нөхөн хангаж, алба хаагчдын нийгмийн баталгаа хангагдаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдсэн байна.

6.4.5.Төв болон бүсийн нэгжүүдэд 65-80 хувийг стандартад нийцсэн албаны эрэлч нохойгоор хангасан байна.

6.4.6.Эрэлч нохойн тоног хэрэгслээр сургалт, бэлтгэлийн төв болон бүсийн төвийн эрэлч нохойн сургалтын нэгжүүдэд 90 хувь хүртэл хангасан байна.

Долоо.Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

7.1.Хөтөлбөрийг 2026–2030 онд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ. Үүнд:

7.1.1.Улсын төсөв;

7.1.2.Орон нутгийн төсөв;

7.1.3.Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, санхүүжилт;

7.1.4.Түншлэл, хамтын ажиллагаа ба хандивын эх үүсвэр;

7.1.5.Бусад эх үүсвэр.

7.2. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн нэгдсэн төсвийн тооцоо болон холбогдох тооцоо үнийн дүнгийн мэдээллийг 2026 оны 2 дугаар улирлын байдлаар тооцож гаргасан. (Цаашид инфляцын нөлөөллөөс шалтгаалан үнийн түвшин өсөх хандлагатай байна)

Найм.Хөтөлбөр, төлөвлөгөөний үндсэн чиглэл

Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2026-2030 оны хугацаанд 4 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

I үе шат: 2026-2027 он

✓ Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэгчээс Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн хэрэгцээ, шаардлага, хүсэлтийг төслийг санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх, гэрээ байгуулах;

II үе шат: 2027-2028 он

✓ Хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, нохойн болон дасгалжуулагчийн тоног хэрэглэл, үнэр орлуулагч, эрэлч нохойн жагсаалтыг гаргаж хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлж санал солилцох;

✓ Хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн гэрээний хүрээнд тохирсон тоног хэрэглэл, тоног төхөөрөмж, эрэлч нохойг сонгох.

III үе шат: 2028-2029 он

✓ Улсын төсөвт Онцгой байдлын ерөнхий газрын бүтцэд Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв, Бүсийн төвүүдийн эрэлч нохойн сургалтын нэгжүүдийн орон тоо, зардлыг төсөвлөн батлуулах;

✓ Хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл хэрэгжүүлэгч болон санхүүжүүлэгч талтай хамтран Эрэлч нохойн сургагч багш, хөтлөгчдийг сургаж бэлтгэх;

✓ Хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн санхүүжилтээр Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн барилга, байгууламжийг барих.

IV үе шат: 2029-2030 он

✓ Хөтөлбөр, төлөвлөгөө, төслөөр байгуулагдсан барилга байгууламж, нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмж, хэрэглэлийг хүлээлгэн өгөх;

✓ Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлэн сургалт, дадлагыг зохион байгуулах.

Ес. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэгч

9.1.Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд. Үүнд:

9.1.1.Бодлого төлөвлөлтийн газар: Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төслийн гэрээг байгуулах, бодлогын баримт бичиг боловсруулах, Олон улсын холбогдох стандарттай уялдуулан журам боловсруулж батлуулах.

Хариуцан ажиллах албан тушаалтан:

✓ Тус газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

✓ Тус хэлтсийн Төсөл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн;

9.1.2.Ажиллагааны удирдлагын газар: Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, удирдлага, зохион байгуулалтаар хангах, холбогдох эрх зүйг боловсруулж, батлуулахад дэмжлэг үзүүлж ажиллах.

Хариуцан ажиллах албан тушаалтан:

- ✓ Тус газрын Газар хөдлөлт, хот дотор эрэн хайх, аврах ажиллагааны хэлтсийн дарга;
- ✓ Тус хэлтсийн Аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн.

9.1.3.Захиргаа эрх зүй, хүний нөөцийн газар: Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв болон бүсийн төвийн эрэлч нохойн сургалтын нэгжүүдийн алба хаагчдын албан тушаалын тодорхойлолт, бүтэц, орон тоог боловсруулж батлуулах.

Хариуцан ажиллах алба хаагчдын албан тушаал:

- ✓ Тус газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга;
- ✓ Тус хэлтсийн Хүний нөөцийн бодлого-төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;

9.1.4.Санхүү, ар талын газар: Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүжилт, холбогдох худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн болон бүсийн төв дэх эрэлч нохойн сургалтын нэгж, орон нутаг дахь эрэлч нохой, нохой хөтлөгч нарын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр барилга, байгууламжийг барьж байгуулах, сургалтын төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Хариуцан ажиллах албан тушаалтан:

- ✓ Тус газрын Барилга, техникийн засвар, үйлчилгээний хэлтсийн дарга;
- ✓ Тус хэлтсийн Төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн.

9.1.5.Гамшгаас хамгаалах сургалтын газар: Эрэлч нохой хөтлөгч бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, зохион байгуулах (төрөл мэргэжил нэг бүрээр) эрэлч нохой бэлтгэх сургалтыг үе шаттайгаар удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.

Хариуцан ажиллах албан тушаалтан:

- ✓ Тус газрын Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хэлтсийн дарга;
- ✓ Тус хэлтсийн Аврах ажиллагааны сургалт хариуцсан мэргэжилтэн;

9.2.Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Үндэсний эрэлч нохойн төв: Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн нурангийн талбайн, сургалтын блокууд, албаны байрны гадна талбайн, мал эмнэлгийн байрны ерөнхий зураг, дулаан авто зогсоолын төлөвлөлтийн зураг, судалгаа, холбогдох төсөв, тооцооллыг боловсруулах, Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүдэд холбогдох чиглэлийн дагуу материалыг хүргүүлэх, шаардлагатай дэмжлэгийг авах, биечлэн хэрэгжүүлж ажиллах.

Хариуцан ажиллах албан тушаалтан:

- ✓ Эрэлч нохой сургалтын төвийн дарга;
- ✓ Эрэлч нохойн сургалтын төвийн малын эмч;
- ✓ Эрэлч нохойн сургалтын төвийн багш нар.

9.3.Бүсийн (Хангай, Баруун, Хойд, Зүүн, Говийн) төвүүдэд Эрэлч нохойн сургалтын нэгж байгуулах бэлтгэл (газар, талбай, барилга, байгууламж, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт)-ийг хангах.

Хариуцан ажиллах албан тушаалтан:

- ✓ Бүсийн төв дэх Онцгой байдлын байгууллагын орлогч дарга;
- ✓ Бүсийн төв дэх Онцгой байдлын байгууллагын Эрэн хайх, аврах нэгжийн дарга, захирагч;
- ✓ Бүсийн төв дэх Онцгой байдлын газрын нягтлан бодогч;

- ✓ Бүсийн төв дэх Онцгой байдлын байгууллагын Эрэн хайх, аврах нэгжийн Эрэлч нохой хөтлөгч нар.

9.4.Орон нутаг дахь Онцгой байдлын байгууллагын Эрэн хайх, аврах нэгж:

Орон нутаг дахь Эрэлч нохойн бэлтгэл (газар, талбай, барилга, байгууламж, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт)-ийг хангах.

Хариуцан ажиллах албан тушаалтан:

- ✓ Орон нутаг дахь Онцгой байдлын байгууллагын орлогч дарга;
- ✓ Орон нутаг дахь Онцгой байдлын байгууллагын Эрэн хайх, аврах нэгжийн дарга, захирагч;
- ✓ Орон нутаг дахь Онцгой байдлын байгууллагын нягтлан бодогч;
- ✓ Орон нутаг дахь Онцгой байдлын байгууллагын Эрэн хайх, аврах нэгжийн Эрэлч нохой хөтлөгч нар.

9.5.Хөтөлбөр, төлөвлөгөөний төслийн санхүүжүүлэгч байгууллага:

Онцгой байдлын байгууллагын Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв болон бүс, орон нутаг дахь эрэлч нохойн сургалтын нэгжийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээнд заагдсан холбогдох эрх, үүргийг хэрэгжүүлэх.

Арав. Хөтөлбөр, төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төв (K9) болон Хангай, Баруун, Хойд, Зүүн, Говийн бүсүүдэд Эрэлч нохойн сургалтын нэгж байгуулах (2026-2030 он) хөтөлбөр, төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2027 оноос жил бүр, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Үндэсний эрэлч нохойн төвөөс төслийг боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүдээс саналыг авч нэгтгэж, Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын даргаар батлуулж, хэрэгжилтэд Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд хариуцсан чиглэлийн дагуу хяналт тавьж ажиллана.

10.2.Хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан ажил, зарцуулсан хөрөнгийн тайланг 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор хагас жилээр, 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор бүтэн жилээр холбогдох хариуцах албан тушаалтан (9.1-9.4-д заасан) үр дүнг тухай бүрд нь харьяа удирдлагад илтгэх хуудсаар дүгнэлт, саналын хамт танилцуулна.

10.3.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүрийн 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор хагас жилээр, 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор бүтэн жилээр Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төв нэгтгэж, Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газарт хүргүүлнэ.

10.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талаас нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Арван нэг. Шагнал урамшуулал

Урамшууллын хэлбэр. Үүнд:

- Мөнгөн шагнал, тусгай нэмэгдэл олгох;
- Дотоод болон олон улсын сургалт, дадлага солилцоонд хамруулах;
- Өргөмжлөл, батламж, мэргэшлийн түвшин ахиулах.

Арван хоёр. 2026-2030 оны стратеги төлөвлөгөө

1.Алсын хараа (Vision)

Олон улсын холбогдох стандартад нийцсэн, гамшгийн нөхцөлд ажиллах эрэлч нохой болон тэдний хөтлөгчийг бэлтгэдэг үндэсний хэмжээний мэргэшсэн төвийг бий болгох.

2.Эрхэм зорилго

Эрэлч нохой болон хөтлөгчийг мэргэжлийн түвшинд сургах, сургалтын орчин, дэд бүтэц, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрэн хангаж, гамшиг, аюулт үзэгдэл, ослын үеийн эрэн хайх, аврах ажиллагаанд үр дүнтэй ажиллах, эрэлч нохойн сургалтын нэгжүүдийг хөгжүүлэх.

3.Стратегийн зорилтууд

- Эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Сургалтын төвийн дэд бүтцийг бий болгох;
- Сургалтын хөтөлбөр, стандартыг хөгжүүлэх;
- Хүний нөөцийг чадавхжуулах;
- Эрэлч нохойг сонгон шалгаруулах, бэлтгэх;
- Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

4.Зорилт 1. Эрх зүйн орчныг бүрдүүлэх

- Эрэлч нохойтой ажиллах журам, заавар, дүрэм боловсруулах;
- Олон улсын холбогдох стандартыг дотоод журамд уялдуулах;
- Сургалтын нэгжийн бүтэц, түүний үйл ажиллагааны журмыг боловсруулах.

5.Зорилт 2. Сургалтын дэд бүтцийг хөгжүүлэх

- Нурангийн сургалтын талбай байгуулах;
- Дотор, гадаах сургалтын байр барих;
- Мал эмнэлгийн болон нэгдсэн нохойн байр байгуулах;
- GPS, камерын тоноглол нэвтрүүлэх.

6.Зорилт 3. Сургалтын чанарыг сайжруулах

- Сургалт (хэрэглэлтэй дасгалын)-ын талбайг бүрдүүлэх;
- Стресс, тест, багийн ажиллагааны сургалтын симуляци хийх.

7.Зорилт 4. Хүний нөөцийг чадавхжуулах

- Эрэлч нохой хөтлөгчийн шаталсан сургалтыг зохион байгуулах;
- Техникийн хайгуулын мэргэжилтэн, сургагч багш сургах;
- Үнэлгээний комиссыг бэлтгэх;

8.Зорилт 5. Эрэлч нохойг бэлтгэх

- Сонгон шалгаруулалтын шалгуур тогтоох;

9.Зорилт 6. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх

- Олон улсын холбогдох сургалт, шалгалтад оролцох;
- Олон улсын хот дотор эрэн хайх, аврах багуудтай хамтарсан дадлага хийх;

10. Хэрэгжилтийн төлөвлөгөө (товч)

2026–2027: Эрх зүй, зураг төсөл боловсруулалт;

2027–2028: Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн нурангийн талбайн барилга;

2028–2029: Тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах;

2029–2030: Эрэлч нохой, хөтлөгчийн сургалтын эхлэл;

2029–2030: Олон улсын ажиллагааны ажлын нохойн шалгалтад хамрагдах үеийн сургалт, хамтын ажиллагаа.

11. Хүлээгдэж буй үр дүн

- Олон улсад болон бүс нутагт эрэн хайх, аврах үйл ажиллагаанд эрэлч нохойн нэгж ажиллах боломжтой болох;
- Нуранги дээр хүний амь насыг аврах хугацааг хэмнэх;
- Бүсийн аврах ажиллагааны чадавх нэмэгдэнэ;
- Олон улсын холбогдох гэрчилгээтэй эрэлч нохойн багтай болно.

**ҮНДЭСНИЙ ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙН ТӨВИЙН
НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО**

**Нэг. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн нэгдсэн төсөв
/жишиг тооцоо/**

№	Зардлын ангилал	Тооцоолсон дүн (төгрөг)
1	Барилга байгууламж	23,855,948,590
2	Сургалтын талбай	248,262,045
3	Тоног төхөөрөмж, хэрэгсэл	369,450,000
4	Тээврийн хэрэгсэл	1,230,000,000
5	Сургалт, хүний нөөц	440,000,000
6	Бусад зардал	858,000,000
Нийт		27,001,660,635

Хоёр. Үндэсний эрэлч нохойн сургалт, бэлтгэлийн төвийн нэгдсэн төсвийн задаргаа

Д/д	Төсөвлөж буй бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ	Үзүүлэлт	Тоо	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
Нэг. Барилга байгууламж					
1	Үндэсний аврагч нохойн төвийн байр	Штаб, ажилчдын оффис өрөө, хичээлийн танхим, цэргийн байр гал тогоо, агуулах багтаасан байх	1	22,888,360,220	22,888,360,220
2	Мал эмнэлгийн байр	Эмчилгээ үйлчилгээ явуулах боломжтой, 6 нохой тусгаарлаж эмчилгээ үзүүлэх боломжтой байх	1	123,762,600	123,762,600
3	Дотор сургалтын байр	Дотоод орчинд сургалт явуулах боломжтой байх	1	248,127,200	248,127,200
4	Нэгдсэн нохойн байр	Аврагч нохойн стандарт байр байх	30	3,956,933	118,707,990
5	Авто машины граж	Тооцоолж буй 7 машин багтах хэмжээтэй байх	1	476,990,580	476,990,580
Нийт:			34	23,855,948,590	

Хоёр. Сургалтын талбай					
1.	Сургалтын нэгдсэн талбай	Байгалын бартаа саадыг дуурайлгасан 10-15 саадаар тоноглогдсон байх, үнэрийн дадлагын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх, Бодит орчныг дүрсэлсэн гадна орчин болон дотор орчны дадлага сургуулилт явуулах боломжтой байх	1	248,262,045	248,262,045
Нийт:			1	248,262,045	
Гурав. Тоног төхөөрөмж хэрэгсэл					
3.1. Тал хээр, ой модны орчинд эрэн хайх, аврах ажиллагааны үед					
1	GPS	Байршил илрүүлэх дохио өгөх	8	250.000	2,000,000
2	Цээживч /цацруулагчтай/	Тод өнгө бүхий цацруулагчтай хол зайд яваа нохойг хянах	8	100.000	800,000
3	Хүзүүвч	GPS хүзүүнээс зүүх хөтөлгөөнд хажууд авч явах	8	75.000	600,000
4	Урт оосор	Эрлийн ажиллагаанд нохойг чиглүүлэх	8	50,000	400,000
5	Усны сав	Нохойг услах	8	15,000	120,000
6	Идүүр	Нохойг хооллох	8	20,000	160,000
7	Богино хөтөлгөө	хөтөлгөөнд хажууд авч явах	8	45,000	360,000
8	Куртик /Цаснаас эрэн хайх ажиллагаанд/	Хунгар зузаан цасанд эрлийн ажиллагаа явуулах үед нохойг дулаалах	8	65,000	520,000
Нийт:			64	4,960,000	
3.2. Усны орчинд эрэн хайх, аврах ажиллагааны үед					

1	Усны хантааз	Нохойг усанд живүүлэхгүй байх	8	150,000	1,200,000
2	Хүзүүвч	хөтөлгөөнд хажууд авч явах	8	75.000	600,000
3	Урт оосор	Эрлийн ажиллагаанд нохойг чиглүүлэх	8	50,000	400,000
4	Усны сав	Нохойг услах	8	15,000	120,000
5	Идүүр	Нохойг хооллох	8	20,000	160,000
6	Богино хөтөлгөө	хөтөлгөөнд хажууд авч явах	8	45,000	360,000
Нийт:			48	2,840,000	
3.3. Нуранги дундах эрэн хайх, аврах ажиллагааны үед					
1	GPS	Байршил илрүүлэх дохио өгөх	8	250.000	2,000,000
2	Камер, дүрс дамжуулагч	Байршлын цагийн байдлыг хянах	8	200,000	1,600,000
3	Цээживч /ажиллагааны/	Нохойнд ил шарх гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх	8	100.000	800,000
4	Хүзүүвч/ цацруулагчтай/	Аврагч нохой явааг илэрхийлэх	8	75.000	600,000
5	Урт оосор	Эрлийн ажиллагаанд нохойг чиглүүлэх	8	50,000	400,000
6	Усны сав	Нохойг услах	8	15,000	120,000
7	Идүүр	Нохойг хооллох	8	20,000	160,000
8	Богино хөтөлгөө	хөтөлгөөнд хажууд авч явах	8	45,000	360,000
9	Гэрэлтүүлэгч	Үзэгдэх орчныг нэмэх	8	45,000	360,000
10	Бойтог	Нохойн хөлөнд ил шарх гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх	8	50,000	400,000
Нийт:			80	6,800,000	
3.4. Мал эмнэлгийн тоног төхөөрөмж					
1	Мал эмнэлгийн тоног төхөөрөмж	Эрэлч нохойн эрүүл мэндийг хамгаалах	1	144,850,000	144,850,000
Нийт:			1	144,850,000	

3.5. Үнэрийн хэрэглэгдэхүүн					
1	Мэргэжлийн дасгал сургалтын үнэрийн хэрэглэгдэхүүн	Эрэлч нохойн үнэрийн чадамж сайжирна	4	15,000,000	60,000,000
Нийт:			4	60,000,000	
3.6. Сургалтын тоног төхөөрөмж					
1	Сургалт, дадлага хичээлийн хэрэглэгдэхүүн	Сургалт дадлагын орчин бүрдэнэ	Иж бүрдэл	150,000,000	150,000,000
Нийт:				150,000,000	
Нийт дүн:			-	369,450,000	
Дөрөв. Тээврийн хэрэгсэл					
1.	Суудлын автомашин	Албаны зориулалтаар ашиглах	1	70.000.000	70.000.000
2.	Дуудлагаар ажиллах үед бүлгийг тээвэрлэх автомашин	Туулах чадвартай, дуудлагаар албан хаагч болон аврагч нохойг тээвэрлэх боломжтой байх	4	170.000.000	680.000.000
3.	10 дээш хүн, нохой тээвэрлэх дунд оврын автобус	Сургалт дадлагаар ажиллах үед албан хаагчид болон нохойг олноор тээвэрлэх боломжтой байх	1	400.000.000	400.000.000
4.	Үйлчилгээний ачааны авто машин	Тоног хэрэгсэл зөөх ачааны хэсэгтэй, даацтай байх	1	80.000.000	80.000.000
Нийт:			7	1,230,000,000	
Тав. Сургалт хүний нөөц					
1.	Мэргэжилтэн бэлтгэх сургалт	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна	5	50	250.000.000
2.	Эрэлч- нохой хөтлөгч нарын мэргэшүүлэх сургалт	Хөтлөгч нар сургалтад хамрагдсан байна	19	10	190.000.000

Нийт:			24	440,000,000	
Зургаа. Бусад зардал					
1.	Өрөө тасалгааны тохижилт, тавилга	Сандал, ширээ, бичгийн шүүгээ, хувцасны шүүгээ	120	1,000,000	120,000,000
2	Цахим тоног төхөөрөмж	(Компьютер, хэвлэх хувилах төхөөрөмж холбооны хэрэгсэл)	200	1,500,000	300,000,000
3.	Нохойн хоол	Стандартад хангасан зориулалтын хоол	9000	18,000	162,000,000
4.	Эрэлч нохой худалдан авах	Үүлдэр стандарт хангасан, албанд тэнцэх нохой	24	10,000,000	240.000.000
5	Түлш Шатахуун	Сургалт дадлага, өдөр тутмын үйл ажиллагаанд зарцуулах	12	3,000,000	36,000,000
Нийт:			858,000,000		
БҮГД ДҮН			27,001,660,635		


--oOo--

ҮНДЭСНИЙ ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙН ТӨВИЙН БҮТЭЦ
ОРОН ТООНЫ ЗАГВАР
/Санал/

Д/д	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл		Орон тоогоор	Тайлбар
1	Төвийн дарга /захирагч/	Офицер	ТТ-3	1	
2	Төвийн орлогч бөгөөд сургалтын албаны дарга		ТТ-4	1	
3	Сургалтын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн		ТТ-5	1	
4	Эрэн хайх, аврах ажиллагааны сургалт хариуцсан ахлах багш		ТТ-6	1	
5	Тэсрэх, дэлбэрэх бодисын сургалт хариуцсан ахлах багш		ТТ-6	1	
6	Сурагч багш		ТТ-7	3	
7	Малын их эмч		ТТ-5	1	
8	Ар тал, хангалт хариуцсан ахлах мэргэжилтэн		ТТ-6	1	
9	Ахлах Нягтлан бодогч		ТТ-5	1	
10	Хүний нөөц дотоод ажил хариуцсан мэргэжилтэн		ТТ-5	1	
11	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахиу хариуцсан мэргэжилтэн		ТТ-6	1	
12	Эрэлч нохой хөтлөгч	Ахлагч	ТТ-7	14	
13	Малын эмч, сувилагч		ТТ-7	4	
14	Гөлгөн нохойн дасгалжуулагч		ТТ-8	3	
15	Бичиг хэргийн ажилтан		ТТ-7	1	
16	Нярав		ТТ-7	2	
17	Жолооч		ТТ-7	6	
18	Үйлчилгээний ажилтан жолооч	Энгийн	ТҮ-5	1	
19	Тогооч		ТҮ-6	1	
20	Цахилгаанчин		ТҮ-4	1	
21	Сан техникч		ТҮ-6	3	
22	Үйлчлэгч		ТҮ-4	2	
Бүгд				51	

Тайлбар: Үндэсний эрэлч нохойн төвийн бүтэц, орон тоог олон улсын жишиг бүтэц, загвараас жишээ болгож боловсруулав. Цаашид өөрчлөн боловсруулна.

ҮНДЭСНИЙ ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ



--oOo--


АЛБАНЫ БАЙРНЫ ЗАГВАР, ТООЦОО

Д/д	Ажлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ (₮)	Дүн (₮)
1	Дулаалгын хавтан	9642	520,000	5,013,840,000
2	Спорт заалны ган арам (дээвэр)	2400	650,000	1,560,000,000
3	Спорт заалны дээврийн сэндвич	2400	240,000	576,000,000
4	Дээврийн дулаалга	4100	180,000	738,000,000
5	Спорт заалны ханын сэндвич	1666	220,000	366,520,000
6	Гадна фасад	1394	320,000	446,080,000
7	Цонх	655	900,000	589,500,000
